



**ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2020 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 48

Мандалговь

Э.Уугандоржийг албан тушаалд нэр
дэвшүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 7 дугаар зүйлийн 7.2 дахь заалт, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5.4 дэх заалт, Төрийн албаны зөвлөлийн тус аймаг дахь салбар зөвлөлийн 2020 оны 5 дугаар хуралдааны шийдвэр, төрийн захиргааны удирдах болон гүйцэтгэх албан тушаалын сонгон шалгаруулалтын комиссын 2020 оны 6 дугаар сарын 8-ны өдрийн хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


Нэг. Хүнс хөдөө аж ахуйн газрын Малын генетик нөөцийн ашиглалт, эрчимжүүлэлт, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн асуудал, тайлан мэдээ хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтад Эрдэнэбилэгийн Уугандорж 62.2 оноогоор тэнцсэн тул тухайн албан тушаалд нэр дэвшүүлсүгэй.

Хоёр. Ажлын байрны шаардлагыг хангаж байгаа Э.Уугандоржийн санал, дүгнэлтийг хавсралтаар баталж, холбогдох материалыг томилох эрх бүхий албан тушаалтанд хүргүүлэхийг салбар зөвлөлийн ажлын албанд даалгасугай.

ДАРГА

Ц.ЭРДЭНЭСҮРЭН

7-80021051



**Хүнс хөдөө аж ахуйн газрын Малын генетик нөөцийн ашиглалт, эрчимжүүлэлт,
мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн асуудал, тайлан мэдээ
хариуцсан мэргэжилтний албан тушаалд нэр дэвшүүлсэн
Эрдэнэбилэгийн Уугандоржийн тухай дүгнэлт**

1. Э.Уугандорж нь 1985 онд Дундговь аймгийн Сайнцагаан сумын төвд төрсөн. 35 настай. Эмэгтэй.
2. Боловсролын байдал: Хөдөө аж ахуйн их сургуулийг 2004-2008 онд Мал зүйн удирдлагын бакалавр зэрэгтэй суралцаж төгссөн. Мал зүйн удирдлага мэргэжилтэй.
3. Ажлын туршлага: 20010-2018 онд Говь-Угтаал сумын ЗДТГ-т Мал эмнэлэг үржлийн тасгийн дарга, 2018-2019 онд МБСБ-ын ГБАЗТ-ийн арга зүйч, 2020 оноос аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын Мал үржлийн албанд мэргэжилтнээр ажиллаж байна.
4. Э.Уугандоржийн төрийн захиргааны албанд ажиллаж байгаа ажлын дадлага туршлага, тухайн ажлын байрны ерөнхий болон тусгай шаардлагыг хангаж байгаа болон тухайн албан тушаалын сонгон шалгаруулалтад тэнцсэн зэргийг харгалзан аймгийн Хүнс хөдөө аж ахуйн газрын Малын генетик нөөцийн ашиглалт, эрчимжүүлэлт, мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн асуудал, тайлан мэдээ хариуцсан мэргэжилтний албан тушаалд томилуулах санал, дүгнэлтийг гаргаж байна.

ТӨРИЙН АЛБАНЫ САЛБАР ЗӨВЛӨЛ